

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн Хамгаалах хариуцлагын Ази, Номхон далайн товтэй хамтран “Иргэдийг хамгаалах хариуцлага” сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг энэ 5 дугаар сарын 5 ны одор зохион байгууллаа. Тус бага хуралд Австралийн Брисбэн хот дахь Куйнсландын их сургууль дээр тов нь байрладаг Хамгаалах хариуцлагын Ази, Номхон далайн товийн гүйцэтгэх захирал, Филиппиний хотолборийн зохицуулагч доктор Ноэл Морадо, товийн гадаад хамтын ажиллагаа хариуцсан захирал хатагтай Сара Тэйт нар хүрэлцэн ирлээ.

Бага хуралд “Хамгаалах хариуцлага: тvvх ба хогжил” илтгэлийг хатагтай Сара Тэйт /АНУ/, “Хамгаалах хариуцлагыг хэрэгжvvлэхэд Ази, Номхон далайн орнуудын vvрэг ба зохицуулалт” илтгэлийг доктор Ноэл Морадо

/Филиппин/, “НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаа ба Монгол улсын оролцоо: Туршлага, сургамж” илтгэлийг БХУА-ийн Энхийг дэмжих ажиллагааны тэнхимийн дарга, дэд хурандаа Ц.Гандорж, Олон улсын эрvvгийн шvvхийн дvрмийг Монгол улсын эрvvгийн хууль, эрvvгийн байцаан шийтгэх хуультай харьцуулан vзэх нь” сэдвээр Хууль зvйн vндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд, Торийн удирдлага, бодлого судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Б.Бат-Ероол нар хоёр оор онцгоос илтгэл тавьж хэлэлцvvлсэн.

Илтгэлvvдийн хэлэлцvvлэг, ярилц-лагын явцад Ромын дvрмээр заагдсан аймаглан устгах [genocide], цэргийн гэмт хэрэг [war crime], угсаатны цэвэрлэгээ [ethnic cleansing], хvн торолхтний эсрэг гэмт хэрэг [crime against humanity] зэргээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах талаар олон улсын хамтын нийгэмлэгээс авч хэрэгжvvлж ирсэн арга хэмжээний vр дvн, туршлага сургамжийг бодит жишээн дээр тулгуурлан шvvн хэлэлцэж, олон улсын эрх зvйн хэм хэмжээ орчин veийн шаардлагад хэрхэн нийцэж буй тухайд судлаачид санал бодлоо уралдуулав.

Бага хуралд монголын талаас БХЯ, ГХЯ, ЗХЖШ, ҮАБЗ-ийн Ажлын алба, Хvний эрхийн Үндэсний комисс, БХИС, МУИС-ийн ОУХС, Удирдлагын академи, Стратегийн судалгааны хүрээлэн, Хууль зvйн vндэсний хүрээлэн, Торийн удирдлага, бодлого судлалын хүрээлэн, Хvний эрхийн Эмнести интернэшнл байгууллага зэрэг торийн болон иргэний нийгмийн байгууллагын толоолол оролцож, ажил хэрэгч ярилцлага орнvvлэн, нэгдсэн ойлголтод хүрлээ. Ярилцлагын явцад МУИС-ийн ОУХС-ийн багш, доктор Баттогтохын Монгол Улсын аюулгvй байдлыг хангах эрх зvйн орчны асуудлаар хийсэн судалгааны ажлын vр дvнгийн мэдээлэл онцгой анхаарал татаж байлаа.